



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын филарманийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/191/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: <a href="mailto:naramchimegts@audit.gov.mn">naramchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:natsagdorjs@audit.gov.mn">natsagdorjs@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ц.Батсүх Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:batsukhts@audit.gov.mn">batsukhts@audit.gov.mn</a> Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг Утас: 70169029 Цахим хаяг: <a href="mailto:info@misheelodaudit.mn">info@misheelodaudit.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



УЛСЫН ФИЛАРМОНИЙН ЗАХИРАЛ  
С.БАТТУЛГА ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/826  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын филармонийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 508,215.3 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 201,200.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бараа материал эд хогшил, урсгал засварын зардал 150,010.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 441,790.1 мянган төгрөг, томилолт, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 117,586.9 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 28.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь тайлант онд Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр Улсын филармонид 1,736,467.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, нийлүүлснээс 1,310,467.0 мянган төгрөгийн хөрөнгийг нийлүүлэгч компаниудаас шууд хүлээлцүүлж биелэлтэд хяналт тавиагүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй, барааг хүлээлгэж өгөөгүй байхад 426,000.0 мянган төгрөгийн төлбөрийг яамнаас бүрэн төлсөн байна.

### **Бусад асуудал**

Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан "Go Mongolia" хөтөлбөрийн хүрээнд морин хуурын чуулга БНСУ-ын нийслэл Сөүл хотноо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бүгд Найрамдах Узбекистан улс, Туркменистан Улсад төрийн айлчлал хийхэд Улсын филармонийн "Морин хуур найрал хөгжим" бүрэн хэмжээний тоглолтоо толилуулсан байна.

Санхүүгийн тайланд өгөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>368,224,165.00</b>	<b>545,772,690.99</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>100.00</b>	-
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>100.00</b>	-
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	100.00	-
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	100.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>17,500,000.00</b>	<b>69,054,065.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	321,065.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	17,500,000.00	68,733,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>350,724,065.00</b>	<b>476,718,625.99</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>208,743,885.00</b>	<b>231,441,805.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	208,743,885.00	231,441,805.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	78,069,900.00	105,319,900.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>63,910,280.00</b>	<b>139,956,920.99</b>
35410	Бичиг хэргийн материал	2,138,480.00	654,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	24,774,711.00	117,923,058.49
35470	Бусад хангамжийн материал	36,997,089.00	21,379,262.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,124,615,009.53</b>	<b>3,048,524,525.20</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,124,615,009.53</b>	<b>3,048,524,525.20</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,119,453,989.94</b>	<b>2,958,854,061.36</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	306,200,000.00	306,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(120,283,333.32)	(149,677,777.74)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,639,633,566.70	3,854,582,816.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(754,474,741.62)	(1,142,305,420.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,338,184.50	137,538,184.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42,959,686.32)	(56,223,543.69)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	8,963,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(224,097.51)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,161,019.59</b>	<b>89,670,463.84</b>
39301	Програм хангамж	6,238,890.00	6,238,890.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,077,870.41)	(2,637,592.85)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	87,500,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,430,833.31)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,492,839,174.53</b>	<b>3,594,297,216.19</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>76,868.47</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>76,868.47</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	-	<b>76,868.47</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	76,868.47
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,492,839,174.53</b>	<b>3,594,220,347.72</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,492,839,174.53</b>	<b>3,594,220,347.72</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	390,738,376.57	390,738,376.57
511001	Өмч: -төрийн	390,738,376.57	390,738,376.57
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,102,100,797.96</b>	<b>3,203,481,971.15</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,723,783,776.36	2,102,100,797.96
51220	Тайлант үеийн үр дүн	378,317,021.60	1,101,381,173.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,492,839,174.53</b>	<b>3,594,297,216.19</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,939,902,387.69</b>	<b>6,947,723,322.41</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>581,835,041.70</b>	<b>1,310,466,969.49</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>581,835,041.70</b>	<b>1,310,466,969.49</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	374,186,250.00	1,184,214,250.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	374,186,250.00	1,184,214,250.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	22,071,050.00	126,252,719.49
120009	Бусад орлого	185,577,741.70	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,358,067,345.99</b>	<b>5,637,256,352.92</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,757,885,700.00</b>	<b>4,847,290,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,757,885,700.00	4,847,290,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>600,181,645.99</b>	<b>789,965,752.92</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,616,246.00	201,200,752.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	410,565,399.99	588,765,000.92
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,561,585,366.09</b>	<b>5,846,342,149.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,561,585,366.09</b>	<b>5,846,342,149.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,426,269,746.31</b>	<b>5,686,708,264.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,852,090,242.24</b>	<b>3,836,937,828.35</b>
210101	Үндсэн цалин	1,762,967,247.88	2,360,485,711.49
210102	Нэмэгдэл	589,842,055.27	766,253,161.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	159,473,282.12	415,456,649.26
210104	Урамшуулал	339,807,656.97	242,123,259.43
210105	Гэрээт ажлын хөлс	-	52,619,047.12
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>360,222,002.94</b>	<b>483,434,225.14</b>
210201	Тэтгэврийн даатгал	248,312,400.73	330,622,725.81
210202	Тэтгэмжийн даатгал	27,975,019.68	39,072,629.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,208,335.59	20,523,197.78
210204	Ажилгүйдлийн даатгал	5,638,017.83	18,710,446.64
210205	Эрүүл мэндийн даатгал	56,088,229.11	74,505,225.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>52,761,000.00</b>	<b>48,491,000.00</b>
210304	Байрны түрээс	52,761,000.00	48,491,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>37,543,909.67</b>	<b>33,899,383.80</b>
210401	Бичиг хэрэг	14,958,830.00	8,259,360.00
210402	Тээвэр, шатахуун	16,913,576.00	18,957,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,871,503.67	6,076,563.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	606,060.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>127,836,519.00</b>	<b>71,607,789.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,287,000.00	150,000.00

210604	Урсгал засвар	116,549,519.00	71,457,789.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>82,845,000.00</b>	<b>76,200,752.00</b>
210701	Гадаад албан томилолт	62,133,000.00	76,200,752.00
210702	Дотоод албан томилолт	20,712,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>426,321,455.01</b>	<b>459,471,465.32</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	424,480,255.01	454,299,465.32
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,331,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	169,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,900.00	172,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	169,300.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>486,649,617.45</b>	<b>676,665,820.83</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	169,557,995.00	235,001,286.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	317,091,622.45	441,664,534.33
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>135,315,619.78</b>	<b>159,633,884.78</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>84,140,600.00</b>	<b>159,241,770.56</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	56,440,600.00	49,660,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	80,881,770.56
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,700,000.00	28,700,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,175,019.78</b>	<b>392,114.22</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,175,019.78	392,114.22
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>378,317,021.60</b>	<b>1,101,381,173.19</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>378,317,021.60</b>	<b>1,101,381,173.19</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,349,593,295.99</b>	<b>5,556,706,602.92</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,349,593,295.99</b>	<b>5,556,706,602.92</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,757,885,700.00</b>	<b>4,847,290,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,757,885,700.00	4,847,290,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>591,707,595.99</b>	<b>709,416,002.92</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,616,246.00	201,200,752.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	402,091,349.99	508,215,250.92
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,324,583,495.99</b>	<b>5,394,946,902.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,324,583,495.99</b>	<b>5,394,946,902.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,189,267,876.21</b>	<b>5,235,313,018.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,844,096,619.19</b>	<b>3,837,231,151.05</b>
210101	Үндсэн цалин	1,738,088,492.61	2,363,128,230.24
210102	Нэмэгдэл	606,783,292.38	762,206,419.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	159,417,177.23	370,662,746.56
210104	Урамшуулал	339,807,656.97	288,614,707.22
210105	Гэрээт ажлын хөлс	-	52,619,047.12
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>373,679,372.35</b>	<b>483,306,972.60</b>
210201	Тэтгэврийн даатгал	257,291,799.25	329,678,872.60
210202	Тэтгэмжийн даатгал	29,175,019.68	38,407,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,508,335.59	19,203,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,748,017.83	19,203,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	57,956,200.00	76,814,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>48,261,000.00</b>	<b>48,491,000.00</b>
210304	Байрны түрээс	48,261,000.00	48,491,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>46,459,410.67</b>	<b>55,279,921.80</b>
210401	Бичиг хэрэг	6,818,090.00	5,914,280.00
210402	Тээвэр, шатахуун	15,862,250.00	18,502,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,871,503.67	6,076,563.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,907,567.00	24,787,078.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>592,800.00</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	592,800.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>228,197,939.00</b>	<b>147,227,689.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,500,000.00	12,230,400.00
210602	Тавилга	1,427,800.00	363,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	59,400,000.00	63,000,000.00
210604	Урсгал засвар	146,870,139.00	71,633,789.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>82,845,000.00</b>	<b>76,200,752.00</b>
210701	Гадаад албан томилолт	62,133,000.00	76,200,752.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>557,635,735.00</b>	<b>587,575,431.69</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	555,794,535.00	582,309,195.32

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,331,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	169,000.00	94,236.37
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,900.00	172,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	169,300.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,500,000.00</b>	<b>100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,500,000.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>135,315,619.78</b>	<b>159,633,884.78</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>84,140,600.00</b>	<b>159,241,770.56</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	56,440,600.00	49,660,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	80,881,770.56
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,700,000.00	28,700,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,175,019.78</b>	<b>392,114.22</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,169,919.39	363,175.62
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,100.39	28,938.60
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>25,009,800.00</b>	<b>161,759,700.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>25,009,700.00</b>	<b>161,759,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>25,009,700.00</b>	<b>161,759,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>25,009,700.00</b>	<b>161,759,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,009,700.00	161,759,800.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(25,009,700.00)</b>	<b>(161,759,800.00)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>100.00</b>	<b>(100.00)</b>
<b>IX</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>X</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>100.00</b>	<b>-</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**  
 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>390,738,376.57</b>	<b>24,023,627.69</b>	<b>1,699,760,151.67</b>	<b>2,114,522,152.93</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	24,023,624.69	24,023,624.69
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>390,738,376.57</b>	<b>24,023,627.69</b>	<b>1,723,783,776.36</b>	<b>2,138,545,777.62</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт бууралт	-	(24,023,624.69)	-	(24,023,624.69)
4	Тайлант үеийн үр дүн	-	-	<b>378,317,021.60</b>	<b>378,317,021.60</b>
11	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>390,738,376.57</b>	-	<b>2,102,100,797.96</b>	<b>2,492,839,174.53</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>390,738,376.57</b>	-	<b>2,102,100,797.96</b>	<b>2,492,839,174.53</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт бууралт	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,101,381,173.19	1,101,381,173.19
20	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>390,738,376.57</b>	-	<b>3,203,481,971.15</b>	<b>3,594,220,347.72</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,847,290,600.00</b>	<b>4,846,927,424.38</b>	<b>363,175.62</b>	<b>99.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,847,290,600.00</b>	<b>4,846,927,424.38</b>	<b>363,175.62</b>	<b>99.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,716,723,500.00</b>	<b>4,716,385,653.82</b>	<b>337,846.18</b>	<b>99.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,826,066,400.00</b>	<b>3,825,931,151.05</b>	<b>135,248.95</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	2,392,210,700.00	2,363,128,230.24	29,082,469.76	98.8
210102	Нэмэгдэл	734,410,600.00	762,206,419.91	(27,795,819.91)	103.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	322,600,000.00	370,662,746.56	(48,062,746.56)	114.9
210104	Урамшуулал	288,845,100.00	277,314,707.22	11,530,392.78	96.0
210105	Гэрээт ажлын хөлс	88,000,000.00	52,619,047.12	35,380,952.88	59.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>482,015,600.00</b>	<b>481,920,872.60</b>	<b>94,727.40</b>	<b>99.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	328,839,500.00	328,744,772.60	94,727.40	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	38,294,000.00	38,294,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,147,000.00	19,147,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	19,147,000.00	19,147,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	76,588,100.00	76,588,100.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>48,500,000.00</b>	<b>48,491,000.00</b>	<b>9,000.00</b>	<b>99.9</b>
210304	Байрны түрээс	48,500,000.00	48,491,000.00	9,000.00	99.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,902,200.00</b>	<b>4,900,993.80</b>	<b>1,206.20</b>	<b>99.9</b>
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	999,580.00	420	99.9
210402	Тээвэр, шатахуун	934,700.00	1,025,500.00	(90,800.00)	109.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,467,500.00	1,376,563.80	90,936.20	93.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,499,350.00	650	99.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>132,492,400.00</b>	<b>132,492,400.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00	-	100.0
210602	Тавилга	22,492,400.00	22,492,400.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	60,000,000.00	60,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>222,746,900.00</b>	<b>222,649,236.37</b>	<b>97,663.63</b>	<b>99.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	219,883,300.00	219,883,000.00	300	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	191,600.00	94,236.37	97,363.63	49.2

210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,000.00	172,000.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>130,567,100.00</b>	<b>130,541,770.56</b>	<b>25,329.44</b>	<b>99.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>130,567,100.00</b>	<b>130,541,770.56</b>	<b>25,329.44</b>	<b>99.9</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	49,684,600.00	49,660,000.00	24,600.00	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	80,882,500.00	80,881,770.56	729.44	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,847,290,600.00</b>	<b>4,846,927,424.38</b>	<b>363,175.62</b>	<b>99.9</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>4,847,290,600.00</b>	<b>4,846,927,424.38</b>	<b>363,175.62</b>	<b>99.9</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,847,290,600.00	4,846,927,424.38	363,175.62	99.9
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	144	141	-	97.9
620003	Үйлчлэх ажилтан	5	4	-	80.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>709,416,002.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>709,416,002.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	680,687,064.32
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	-	11,300,000.00
210104	Урамшуулал	-	11,300,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	<b>1,386,100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	934,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	113,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	56,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	56,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	226,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>50,378,928.00</b>
<b>210401</b>	Бичиг хэрэг	-	4,914,700.00
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	-	17,476,500.00
<b>210403</b>	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	4,700,000.00
<b>210406</b>	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	23,287,728.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>99,631,189.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	18,470,400.00
210602	Тавилга	-	26,527,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	3,000,000.00
210604	Урсгал засвар	-	51,633,789.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>76,200,752.00</b>
210701	Гадаад албан томилолт	-	76,200,752.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>441,790,095.32</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	439,290,095.32
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	28,728,938.60
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	28,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	28,700,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>28,938.60</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	-	28,938.60
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>709,416,002.92</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	709,416,002.92
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	201,200,752.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	508,215,250.92
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 63,993.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 63,993.5 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Ээлжийн амралтын цалинг бодож олгохдоо улсад ажилласан жилийг зөв тооцоогүйгээс 15 ажилтанд 4,443.4 мянган төгрөг дутуу олгосон	1	4,443.4	1	4,443.4	-	-	1	4,443.4	-	-
Санхүүгийн тайлангаар татварын өрийн үлдэгдэл болон татварын тодорхойлолтоорх үлдэгдлийг тулган шалгахад дараах зөрүүтэй байна. Үүнд: 1. Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын авлага санхүүгийн тайланд 24,127.3 мянган төгрөг байхад татварын тодорхойлолтоор 35,257.5 мянган төгрөгийн өглөгтэй буюу 59,384.8 мянган төгрөгөөр зөрүүтэй 2. Автын агаарын бохирдлын төлбөрийн өглөг татварын тодорхойлолтоор 37.3 мянган төгрөг байхад санхүүгийн тайланд тайлагнаагүй 3. Атвотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татварын өглөг татварын тодорхойлолтоор	1	59,550.1	1	59,550.1	-	-	1	59,550.1	-	-

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

128.0 мянган төгрөг байхад санхүүгийн тайланд тайлагнаагүй байна.										
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>63,993.5</b>	<b>2</b>	<b>63,993.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>63,993.5</b>	<b>-</b>	<b>-</b>

**3.2** Аудитаар нийт 68,947.0 мянган төгрөгийн 10 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 4,195.1 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 48,698.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 16,053.1 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оны аудитаар "Тус байгууллагын нийт ажиллагсдын 95.0 хувьд ур чадварын нэмэгдлийг сар бүр тогтмол 10-25 хувиар тооцож хавтгайруулан олгосон, ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, ур чадвартай эсэх нь тодорхойгүй, зөвхөн цалин нэмэгдүүлэх эх үүсвэр болгон олгож байна." гэсэн зөрчилд зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын цахим татварын тодорхойлолтоор 3,835.0 мянган төгрөгийн татварын өглөгийн үлдэгдэлтэй байхад санхүүгийн тайланд татварын өглөгийг тайлагнаагүй байна.	1	3,835.0	-	-	-	-	1	3,835.0
Ээлжийн амралтын цалинг бодож олгохдоо улсад ажилласан жилийг зөв тооцоогүйгээс 1 ажилтанд 320.9 мянган төгрөг илүү олгосон байна.	1	320.9	1	320.9	-	-	-	-

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Ажил гүйцэтгэх гэрээгээр болон ажлын хөлсөөр 53,588.0 мянган төгрөг олгосноос 12,218.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тайлагнаагүй байна.	1	12,218.1	-	-	-	-	1	12,218.1
Баяр наадам, төрийн хүндэтгэлийн үйл ажиллагаанд оролцсон үеэр илүү цаг ажилласан нэмэгдлийг олгохдоо илүү цаг ажилласныг нотлох бүртгэл хөтлөлт хангалтгүй, зөвхөн захирлын тушаалаар олгож, нөхөн амрах хуулийн заалтыг хэрэгжүүлдэггүй байна. Ажлын цагийн бүртгэлийг цахимжуулахаар аппликейшн ашиглаж эхэлсэн боловч үр дүн муутай байна.	1	-	-	-	-	-	1	-
Тус филармонийн цалингийн хүснэгтээс түүвэрчлэн 8 ажилтны илүү цагийн хөлс бодолтыг тулгахад 1 цагийн дундаж цалин хөлсийг буруу тооцоолсноос 6 ажилтанд 936.3 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	936.3	1	936.3	-	-	-	-
Тус байгууллагын 1 ажилтныг тэтгэвэрт гарахад төрийн албанд ажилласан хугацаагаар тэтгэмж олгохдоо хувийн салбарт ажилласан 2 жил 5 сарыг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож 2,297.9 төгрөгийн тэтгэмж илүү олгосон байна.	1	2,297.9	1	2,297.9	-	-	-	-
Тайлант онд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр Улсын филармонид 1,736,467.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэснээс 1,310,467.0 мянган төгрөгийн хөрөнгийг нийлүүлэгч компаниудаас шууд хүлээлцүүлэн олгосон боловч яамнаас хяналт тавиагүй, тооцоо нийлж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүйгээс 426,000.0 мянган төгрөгийн барааг хүлээлгэж өгөөгүй байхад төлбөрийг яамнаас бүрэн төлсөн байна.	1	-	-	-	1	-	-	-
Тус филармонийн жилийн эцсийн тооллогоор дутагдсан 8 ширхэг 640.0 мянган төгрөгийн хөрөнгөд тооллогын комисс акт тогтоож, нөхөн төлүүлэх талаар дүгнэлт, шийдвэр гаргаагүй байна.	1	640.0	1	640.0	-	-	-	-

Тайлант онд худалдан авах ажиллагааг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй, харьцуулалтын аргаар худалдан авах 48,698.8 мянган төгрөгийн урсгал засварын 3 ажлыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.	1	48,698.8	-	-	1	48,698.8	-	-
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>68,947.0</b>	<b>4</b>	<b>4,195.1</b>	<b>3</b>	<b>48,698.8</b>	<b>3</b>	<b>16,053.1</b>

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Тус филармони өмнөх оны аудитаар 14 худалдан авалт хийхээр төлөвлөснөөс худалдан авах бараа, ажил үйлчилгээний үнэ, нэр төрлийг тодорхой, үндэслэлтэй тусгаагүй, төлөвлөгөөнөөс давсан гүйцэтгэлтэй худалдан авалтууд хийсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна.	1	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>